


**“ДАРХАН-ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР”
ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ДАРХАН-УУЛ АЙМАГ

91

**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР”
ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
(2021 он)**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	97,7%	0.58	4.75
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	95%		
	3. Дархан-Уул аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	96%		
	4. Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	98%		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	98%		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	99%	0.18	
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	97,7%		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	87,5%		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100%	0.19	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	99,3%		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	100%		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	95%		
Ерөнхий үнэлгээ:		96,9%	0.95	

ХЯНАСАН: 
ДАРГА Д.БАТБАЯР/
2021 оны 12 сарын 20 өдөр

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:  М.БАТБУЛГАН/
2021 оны 12 сарын 20 өдөр

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

(нийт үнэлгээний 60%)

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Байгууллагын зорилго, зорилт, үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн дагуу Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг дарга байгуулсан 2021 оны газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг бүрэн хангахад "Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ нь үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

1. Монгол Улсын 11 хуулийн 34 заалт
2. Засгийн газрын 1 тогтоолын хавсралт (2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилгын ажлын захиалагчийн дүрэм)
3. Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 2 заалт
4. Сангийн сайлын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 7 заалт
5. Аймгийн Засаг даргын 01-а/313 захирамжийн 1 заалт
6. Аймгийн Засаг даргын 2 албан даалгавар-10 заалт

Дээрхи хууль, тогтоомж, дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2021 оны жилийн эцсийн тайлангаар 97,7 хувийн хэрэгжилттэй 4.8 онооны үнэлгээтэй байна.

(Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаар үнэлүүлэн аймгийн ЗДТГ-ын ТЗҮХ-т 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/513 тоот албан бичгийн хамтаар хүргүүлсэн)

2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус газар нь 2021 онд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 25,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техник хяналтыг хэрэгжүүлж БНБД, стандарт, ажлын батлагдсан зураг төсөл, төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан

баталгаажуулж ажиллалаа. Үүнээс байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн 3 төсөл, арга хэмжээ, 2022 онд шилжин хэрэгжих 7 төсөл арга хэмжээ байна.

Үүнд:

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд: 15,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ

Үүнд:

1. Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажил /Дархан-Уул аймаг, Хонгор сум/-Ажлын явц-50%
2. Хуучин Дархан Спортын ордоны барилга угсралтын ажил –Ажлын явц 50%
3. Цэцэрлэгийн барилга /100 ор/ угсралтын ажил-Ажлын явц-100% Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.
4. Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга угсралтын ажил /Орхон сум, 9-р цэцэрлэг/-Ажлын явц-60%
5. Сургуулийн барилга 480 хүүхдийн суудал-Ажлын явц 70%
6. Музей, номын сангийн цогцолборын барилга-Ажлын явц-30%

Эдийн засгийн бодлогын хүрээнд: 9,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ

1. Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах Мон 3244/3245 төсөл – Ажлын явц 77% -Санхүүжилт-Азийн хөгжлийн банк
2. Дахин төлөвлөлт 60 айлын орон сууцны барилга угсралтын ажил-Ажлын явц 100%. Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.
3. Тосгон чиглэлийн гадна дулааны шугам сүлжээний ажил-Ажлын явц-70%
4. Гэр хорооллын ИШС шинээр татах ажил /Дархан сумын 5-р баг/-Ажлын явц 100%. Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.

3. Дархан-Уул аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт

Дархан-Уул аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан дараах төсөл хөтөлбөрүүдэд манай байгууллага нь захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

Нэг.Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилтын хүрээнд:

Улсын төсвийн 4,9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баригдаж буй “Музей-номын сангийн цогцолбор”-ын 540,3 сая төгрөгийн барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажилласан. 2022 онд уг төсөл нь шилжин хэрэгжинэ.

Хоёр. Хүний хөгжил зорилтын хүрээнд:

Дээрх зорилтын хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөлд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

- Эрүүл мэндийн салбарт 1 төсөл
- Боловсролын салбарт 8 төсөл
- Ахмад, болон залуучуудын хөгжилд зориулсан 2 төсөл

Үүнээс 8 төслийг байнгын ашиглалтад хүлээлгэн ба 3 төсөл 2022 онд үргэлжлэн хэрэгжинэ.

Гурав. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, орон сууцны хангамжийг сайжруулж, дундаж давхарыг хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

Дээрхи зорилтын хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 18,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 51 төсөл хөтөлбөрт захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

- Орлогод нийцсэн орон байр зорилтын 4 төсөл
- Хүнд ээлтэй амьдрах орчин зорилтын 34 төсөл
- Эрүүл аюулгүй, баталгаат орчныг бий болгоно зорилтын хүрээнд 1 төсөл
- Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг зорилтын хүрээнд 13 төсөл

Үүнээс байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн 43 төсөл, 9 төсөл нь 2022 онд үргэлжлэн хэрэгжинэ.

Дөрөв. Эдийн засаг зорилтын хүрээнд:

Дээрхи зорилтын хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 45,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 47 төсөл хөтөлбөрт захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн аймаг болох зорилтын хүрээнд 4 төсөл
- Дэд бүтэц зорилтын хүрээнд 43 төсөл

Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн 38 төсөл, 5 төсөл нь 2022 онд үргэлжлэн хэрэгжинэ.

Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм зорилтын хүрээнд:

Дээрхи зорилтын хүрээнд орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 12 төсөлд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажилласан ба 9 төслийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн ба 3 төсөл нь 2022 онд үргэлжлэн хэрэгжинэ.

4. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Дархан Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 4 бодлогын хүрээнд мэргэжлийн инженерүүд нь 2020-2021 онд шилжин хэрэгжсэн 12 төсөл, 2021 онд шинээр хэрэгжүүлсэн 112 төсөлд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

Үүнд:

1. **Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:** Улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 13,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл

Байнгын ашиглалтад орсон 19 төсөл

2022 онд үргэлжлэн хэрэгжих 7 төсөл

2. **Эдийн засгийн бодлогын хүрээнд:** Улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 59,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл

• Байнгын ашиглалтад орсон 77 төсөл

• 2022 онд шилжин хэрэгжих 15 төсөл

3. **Засаглалын бодлогын хүрээнд:** Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 34,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөлд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажилласан ба байнгын ашиглалтад оруулсан.
4. **Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд:** ОНХС болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 773,1 сая төгрөгийн санхүүжилтээр 3 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба 2 төслийг байнгын ашиглалтад оруулсан.

5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Зорилго, зорилт, үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн дагуу 2021 онд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2020-2021 онд шилжин хэрэгжсэн 26,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээ, 2021 онд шинээр гэрээ байгуулж хэрэгжүүлсэн 52,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 112 төсөл, арга хэмжээ буюу нийт 124 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

Хоёр. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

(нийт үнэлгээний 20%)


1. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2020-2021 онд шилжин хэрэгжсэн 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээ, 2021 онд шинээр гэрээ байгуулж хэрэгжүүлсэн 52,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 112 төсөл, арга хэмжээ буюу нийт 124 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажилласан ба барилга угсралтын ажлын явцад зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагыг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийг мөрдүүлэн тулгамдсан асуудлыг ерөнхий захиалагч, гүйцэтгэгч, зохиогч, болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж техникийн хяналтыг гүйцэтгэн үүрэг даалгаврын биелэлтийг 95,6%-иас дээш хангуулан ажлын явцыг 6614 фото зургаар баримтжуулж үе шатны 1086 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулж, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж санхүүжих гүйцэтгэлийг баталгаажуулж ажилласан байна.

Гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулахдаа төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг ханган магадлашгүй ажил болон бусад хийгдээгүй ажлын зардлаас 163,6 сая төгрөгийг хэмнэсэн.

- Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн-99 төсөл
- 2021-2022 онд үргэлжлэн хэрэгжих 25 төсөл.

2020-2021 онд шилжин хэрэгжсэн 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээ:



2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан.

Зорилт №1 Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж эхлүүлэх, батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулж, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах.

Дээрх зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлж гүйцэтгэлийг 98,3% иар хангуулан ажилласан байна.

- байгууллагын гүйцэтгэлийн хувь-98,3%
- дотоод аудит хариуцсан ажилтны үнэлгээгээр-96,3%
- аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын үнэлгээгээр-96,1% байна.

Зорилт №2 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:

Дээрх зорилтын хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөн 100% хэрэгжүүлж ажиллалаа.

- байгууллагын гүйцэтгэлийн хувь 100%
- дотоод аудит хариуцсан ажилтны үнэлгээгээр 99,2%
- аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын үнэлгээгээр 99,3% байна.

Нийт дундаж гүйцэтгэлийн хувь:

- Байгууллагын гүйцэтгэлийн хувь-99,1%
- Дотоод аудит хариуцсан ажилтны үнэлгээ-97,7%
- Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн үнэлгээ-97,7% байна.

(Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн тайланг аймгийн ЗДТГ ын ХОХБТХ-ийн даргаар үнэлүүлэн аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т 2021 оны 12 дугаар сарын 14 ны өдөр 1/512 тоот албан бичгээр хүргүүлсэн)

3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

/ журмын 4 дүгээр хавсралт/

Сургалт:

Газрын 2021 оны сургалтын төлөвлөгөөгөөр 8 төрлийн сургалтанд ИТА, албан хаагчид нь хамрагдахаар төлөвлөсөн ба үүнээс 7 төрлийн сургалтанд хамрагдсан.

Барилгын инженер Б.Анхбаяр нь Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулж буй "Мэргэшсэн инженер" ийн 10 кредит багц цагийн сургалтад 14 хоног цахимаар хамрагдсан. Сантехникийн инженер Б.Гантуяа нь 2020 онд "Мэргэшсэн инженер"-ийн багц цагийн сургалтад 100% хамрагдсан.

Бичиг хэргийн ажилтан А.Нарангарав нь Архивын ерөнхий газраас зохион байгуулсан "Архив-албан хэрэг хөтлөлт"-ийн сургалтад цахимаар хамрагдаж сертификатаа авсан.

Авто замын инженер Д.Аюурзана нь Үндэсний Дата төвөөс зохион байгуулсан Вэб админ, вэб хуудас хөгжүүлэх сургалтад хамрагдсан. Мөн авто замын хяналтын инженерийн сургалтад хамрагдаж сертификатаа авсан. Мөн ИТА, албан хаагчид нь ерөнхий инженерийн удирдлагаар "Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", Авилгын тухай хуулийн талаар танилцуулга болон "Барилгын зураг төсөл, угсралт, материал,технологи"-ийн шинэ мэдээллүүдээр хийсэн сургалтад хамрагдаж мэдлэг, мэргэшил ур чадвараа дээшлүүлсэн.

Сургалтын төлөвлөгөөний биелэлт 87,5%. Сургалтын төлөвлөгөө, тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т гүйцэтгэлийн тайлангийн хамтаар 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 1/513 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа:

Байгууллагын ИТА албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, автомашин, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хоол унааны мөнгө, сар бүр ур чадварын нэмэгдэл зэргийг олгож ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

2021 оны батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан үндсэн 8 гэрээгээр 4 инженер ажилд аван нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа.

Бүтээн байгуулалтын ажилд багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах мэргэжлийн ур чадвартай мэргэшсэн инженерүүдийг томилон ажиллуулж байна.

Байгууллагын ёс зүйн дүрмийг шинээр батлан мөрдүүлж ажилласан ба ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулж ажилласан.

Ажилчидтай 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан ба ажлын үр дүнг сар бүрийн тайлангийн биелэлт, ажлын гүйцэтгэлийг харгалзан үзэж ур чадварын нэмэгдэлд 12 сая төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 5,9 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон байна.

Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд хүүхдийн баяр, шинэ жилээр инженер техникийн ажилтан, албан хаагчдын 14 хүүхдэд 20,000 төгрөгийн төсөвт өртөгтэй бэлэг гардуулсан ба нийт 560,000 төгрөг зарцуулсан байна. Мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийг сар бүр 15% иар бодож олгосон байна.

Мөн ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс амны хаалт, нэг удаагийн бээлий, витамин С, чацарганын шүүс, аарц зэргийг өгч ажилчдын дархлааг дэмжин ажиллалаа.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

(нийт үнэлгээний 20%)

1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээ

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 124 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэн ажилласан ба аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд долоо хоног бүрийн мягмар гаригт буюу нийт 34 удаа оролцон барилгын ажлын явцын талаар мэдээ тайланг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргуулж байв.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах Мон 3244/3245 төслийн сарын ажлын төлөвлөгөө, сар бүрийн ажлын тайлан, улирлын ажлын тайлан, жилийн ажлын тайланг Дархан төслийн удирдах нэгжид хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан ба худалдан авах ажлын төлөвлөгөө, тайланг аймгийн ОНӨГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авах тухай хуулийн дагуу 2021 онд зарцуулах шатахууныг худалдан авахдаа харьцуулалтын аргаар цахим тендер зарласан ба Содмонгол ХХК шалгарч гэрээ байгуулан худалдан авалт хийлээ.

Мөн 2020 оны гүйцэтгэлийн тайлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т, 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт шинжилгээний үнэлгээний тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-т, 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх гэрээний дагуу санхүүгийн баримтуудыг ЦЭСБ Аудит ХХК-д, 2020 оны үйл ажиллагааны тайланг 2021.02.24 нд аймгийн ОНӨГ, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд, 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т, 2021 онд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ бүрээр

объектын тайлан гаргаж газрын мэдээллийн санг бүрдүүлсэн ба аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хагас болон бүтэн жилээр хүргүүлж ажиллалаа.

2020 оны байгууллагын жилийн эцсийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2021 оны 02 дугаар сард танилцуулсан. Аймгийн Мэдээлэл технологийн албатай 2021 оны 06 дугаар сарын 05 нд "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулсан ба улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хяналтын талаар фото болон дүрст мэдээ, сурвалжилга, шууд дамжуулалт нийт 45-ыг бэлтгэн цахим сүлжээн дэх албан ёсны фэйсбүүк, фэйж хуудсууд /Дархан-Уул аймаг, Дархан хот, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар/ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллалаа. Байгууллагын da.barilga.gov.mn вэб хуудас, Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар цахим хуудсаар мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргүүлэн ажиллалаа. Байгууллагын фэйсбүүк хуудаст байршуулсан барилга угсралтын төсөл, арга хэмжээний мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 63943 хүн харсан ба 1001 хүн дэмжин, 1021 хүн дагасан үзүүлэлттэй байна.

2021 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 408 албан бичиг хүлээн авч бүртгэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан ба 509 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

2. Шилэн дансны хөтлөлтийн талаар

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн байх ёстой.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 148 мэдээлэл байршуулахаас 147 байршуулсан нь 99,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

3. Шударга байдлын түвшний талаар

Судалгаанд хамрагдаагүй.

(Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн дагуу АТГ-ын даргын 2010 оны 59 дүгээр тушаалаар баталсан "Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлж дүгнэдэг. Тайлант онд судалгаанд танай байгууллагын төрийн албан хаагчид хамрагдсан бол хэдэн хүн хамрагдсан талаар бичиж болно. Судалгаанд хамрагдаагүй бол шаардлагагүй)

4. Хэрэглэгчийн үнэлгээ

Ашиглалтад оруулсан барилга байгууламжаас ирүүлсэн санал гомдлын дагуу баталгаат хугацааны засвар үйлчилгээг гүйцэтгэгч байгууллагуудаар хийлгэсэн.

Жишээ нь:

"Багийн төвийн барилга"-д ашиглагч байгууллагуудаас гомдол ирүүлсний дагуу "СБМ"-ХХК иар 11, 12 дугаар багийн төвд дотор заслын ажил, гадна худгийн

ажлыг, 13, 14, 16 дугаар багийн төвд дотор заслын ажил, 15 дугаар багийн төвд дотор заслын ажлыг тус тус хийлгүүлж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

Ноён өндөр констракшн ХХК-ийн гүйцэтгэсэн “Бохир усны шугам хоолойн засвар /Дархан сумын 13 дугаар баг/-ын барилга угсралтын ажилд зөрчлийг арилгуулах тухай албан шаардлага аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсний дагуу 2021 оны 05 дугаар сард барилгын ховхорсон будаг, цонхнуудын тавцанг засаж зөрчлийг арилгуулган хариу албан бичгийг хүргүүлсэн.

Пи си эф ХХК ийн Дархан сумын Өргөө багт гүйцэтгэсэн “Авто замын өргөтгөл, засвар”-ын ажилд гарсан гэмтлийг 2021 оны 08 дугаар сард хийж гүйцэтгүүлсэн.

Жинсийн орой ХХК-ийн гүйцэтгэсэн “Цэцэрлэгийн барилга”-ын дотор заслын ажил, гадна бохир усны шугамын ажил, дээврийн ажилд гарсан гэмтлүүдийг тус компаниар засварлуулсан.

Дөрөв. ТЭРГҮҮН ТУРШЛАГА, БҮТЭЭЛЧ, ШИНЭЛЭГ АЖИЛ

Манай байгууллагын инженерүүд нь багаар ажиллаж хэрэгжиж буй бүх төслүүдэд хувийн хэрэг нээж, зураг төслийг урьдчилан судалж техникийн шийдэл нь тодорхойгүй буюу төсөв, хөрөнгө нь дутуу суугдсан ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж байна.

Тав. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛУУД:

Өмнөх онуудад барилга угсралтын ажилд гарсан алдаа зөрчлүүдэд судалгаа хийж, зөрчлүүдийг давтахгүй байх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД

Засаг даргын түвшинд:

1. Хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаатай холбогдуулж ИТА нарын тоог нэмж бүтэц орон тоог батлуулах.
2. ИТА, албан хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх.
3. Хэмжилт, лабораторийн багаж, тоног төхөөрөмжөөр хангах.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



/Д.БАТБАЯР/

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН: 8171 1521060002 ГС77201

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР...../Ч.БАТБУЛГАН/